



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/282

Улаанбаатар хот

Гадаадын жуулчдад коронавируст халдвар
(КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээ
үзүүлэх заавар батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.3 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5, 8.1.13 дахь заалт, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын жуулчдад коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ерөнхий зааврыг нэгдүгээр, Гадаадын жуулчдыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамруулах, тандалт хийх зураглалыг хоёрдугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглалыг гуравдугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хөнгөн тохиолдлын өөрийгөө хянах хуудсыг дөрөвдүгээр, Түргэн тусламжийн дуудлага хүлээн авах утасны жагсаалтыг тавдугаар, Гадаадын жуулчдад яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглалыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гадаадын жуулчдад үзүүлэх коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Сувд/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт даалгасугай.

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины түр цэг, явуулын багт ажиллах эрүүл мэндийн ажилтны хуваарийг баталж, шаардагдах зардлыг тооцож олгохыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины түр цэгт үйлчлүүлж буй гадаадын иргэнд вакцины дараах урвал, хүндрэл бүртгэгдсэн тохиолдолд яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтний ажиллах хуваарийг батлан хэрэгжүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Б.Хишигжаргал/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Б.Эрдэнэбулган/, аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт даалгасугай.

141220248

5. Монгол Улсын аялал жуулчлалын гол чиглэл болох Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Увс, Ховд, Баян-Өлгий, Өмнөговь, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймагт эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, бэлэн байдлыг хангаж, шуурхай зохион байгуулж ажиллахыг дээрх аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6. Мэргэжил аргазүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

05 Эрүүл мэндийн сайдын 2022 оны
... дүгээр сарын 18 өдрийн А/203 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ГАДААДЫН ЖУУЛЧДАД КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ААС СЭРГИЙЛЭХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

Аялал жуулчлалын салбарыг дэмжих, жуулчдыг татах зорилтын хүрээнд гадаадын жуулчдад коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд энэхүү ерөнхий зааврыг ашиглана.

Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтын зохион байгуулалт

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакциныг дархлаажуулалтын байнгын нэгж, түр цэг, явуулын хэлбэрээр хийнэ.

2.1.1. Нийслэл болон орон нутаг дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын байнгын нэгжийн байршил, хаягийг Эрүүл мэндийн яамны цахим хуудас (<https://moh.gov.mn/p/147>)-наас авна.

2.1.2. Улаанбаатар хотод Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Шангри-Ла худалдааны төв, Сүхбаатарын талбайд дархлаажуулалтын түр цэг ажиллана.

2.1.3 Аялалын баг нь 30-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй тохиолдолд Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс дархлаажуулалтын явуулын баг ажиллана.

2.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамрагдахдаа гадаад паспортаа биедээ авч очно.

2.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамрагдсаны дараа 20-30 минут биеэ ажиглахыг гадаадын жуулчдад зөвлөнө.

2.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамрагдсан гэрчилгээг цахим үйлчилгээний нэгдсэн портал (E-Mongolia)-аас монгол, англи хэлээр үнэ төлбөргүй авна. Цахим хэлбэрээр авах боломжгүй бол вакцинд хамрагдсан тарилгын гэрчилгээг вакцинд хамрагдсан цэгээс авч болно.

2.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины дараах урвал, хүндрэл, сэргийлэлт, авах арга хэмжээний талаар зөвлөгөө, мэдээлэл авах бол мэдээллийн 119 тусгай дугаарын утсанд хандана.

Гурав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, хариу арга хэмжээний зохион байгуулалт

3.1. Хилийн нэвтрэх цэгт:

3.1.1. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинд тохирсон хариу арга хэмжээг шинэчлэх тухай" А/203 дугаар тушаалын дагуу хилийн нэвтрэх цэгт "Эрүүл мэндийн мэдүүлэг"-ийг бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөнө.

3.1.2 Хилийн нэвтрэх цэгт гадаадын жуулчдын биеийн халууныг термокамераар хэмжинэ.

3.1.3. Эрүүл мэндийн мэдүүлэгт 3 ба түүнээс дээш шинж тэмдгийг чагталсан, термокамерийн хяналтаар 38-аас дээш халуурсан иргэнийг хилийн нэвтрэх цэгийн тусгаарлах өрөөнд түр тусгаарлана.

3.1.4. Түр тусгаарлах өрөөнд өөрийн авчирсан антигенд суурилсан түргэвчилсэн тестээр шинжилгээ хийж, хариуг эрүүл ахуй, халдвар хамгаалал хариуцсан гаалийн улсын байцаагчид мэдэгдэнэ.

3.1.5. Антигенд суурилсан түргэвчилсэн тестээр эерэг гарвал хамгийн ойр байгаа эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

3.1.6. Аялал, жуулчлалын компани нь гадаадын жуулчдыг Монгол Улсад ирэхдээ антигенд суурилсан түргэвчилсэн тест 2-оос доошгүй ширхэгийг авч ирэхийг зөвлөнө.

3.2. Аялал, жуулчлалын үед:

3.2.1. "Түр заавар шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/36 дугаар тушаалын 1-р хавсралтын 2.7-д заасан тохиолдлын тодорхойлолтын дагуу халуурах, ханиалгах, хоолой өвдөх, сэрвэгэнэх, толгой өвдөх, хамар битүүрэх, нус гоожих, үнэрлэх, амтлах мэдрэхүй алдагдах, амьсгаадах зэрэг шинж тэмдгээс 3 ба түүнээс дээш илэрвэл аялал жуулчлалын компанийн ажилтанд мэдэгдэнэ.

3.2.2. Дээрх шинж тэмдэг илэрсэн тохиолдолд амны хаалт зүүж, бусдаас өөрийгөө тусгаарлан өөрийн авчирсан антигенд суурилсан түргэвчилсэн тестээр шинжилгээ хийж, хариуг аялал жуулчлалын компанийн ажилтанд мэдэгдэнэ.

3.2.3. Антигенд суурилсан түргэвчилсэн тестээр эерэг гарвал хөдөө орон нутагт бол хамгийн ойр байгаа эрүүл мэндийн байгууллагад, Улаанбаатар хотод Халдварт өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хандаж, бх-ПГУ шинжилгээ хийлгэнэ.

Дөрөв. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг эмчлэх, хянах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн газар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд нийслэлд бол Халдварт өвчин судлалын үндэсний төв (100 дугаарын утас), орон нутагт бол хамгийн ойр байгаа эрүүл мэндийн байгууллагын хариу арга хэмжээний баг эрэмбэлж, үнэлгээ хийн, үйлчлүүлэгчийг түр оршин суугаа газарт нь эмчлэх, хянах, эмнэлгийн нөхцөлд эмчлэх шийдвэрийг гаргана.

4.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хөнгөн тохиолдол нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай" А/33 дугаар тушаалын дагуу эмнэлэгт хэвтүүлэхгүй бөгөөд "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын өөрийгөө хянах хуудас"-ыг бөглөж, түр оршин суух газарт 5 хоног өөрийгөө тусгаарлан ажиглана.

4.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүндэвтэр, хүнд, нэн хүнд тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон нутагт аймгийн Нэгдсэн

эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв хариуцан үзүүлнэ.

4.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүндэвтэр, хүнд, нэн хүнд өвчтөнийг дараагийн шатлалын тусламж үзүүлэх эмнэлэг рүү тээвэрлэхдээ өвчтөн тээвэрлэх зориулалтын машинаар, амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг тогтвортой байлгах бэлтгэлийг ханган, халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан тээвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс нарийн мэргэжлийн эмч нараас заавар зөвлөгөө авч, яаралтай тусламжийг үзүүлэх мэргэжлийн эмчийн хяналтад тээвэрлэхээр зохион байгуулна. Тээвэрлэлтийн хугацаанд шаардагдах хүчилтөрөгчийн нөөцийг машин болон замд цэнэглэх нөхцөлийг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.6. Эрүүл мэндийн сайдын “Жагсаалт, журам батлах тухай” 2022 оны А/216 дугаар тушаалаар баталсан “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ын 2.6-д зааснаар эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй гадаадын болон харьяалалгүй иргэн нь тусламж, үйлчилгээний төлбөрийг 100 хувь эрүүл мэндийн байгууллагад төлнө.

4.7. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн батлах тухай” 1 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.7-д заасны дагуу гадаадын болон харьяалалгүй даатгуулагч нь тусламж, үйлчилгээний төлбөрийн 80 хувьтай тэнцэх төлбөрийг эрүүл мэндийн байгууллагад төлнө.

4.8. Монгол Улсаас бусад улстай байгуулсан Нийгмийн хамгааллын гэрээ, хэлэлцээрт эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудлыг тусгасан тохиолдолд тухайн гэрээ, хэлэлцээрийн зохицуулалтыг баримтална.

4.9. Гадаадын жуулчдад яаралтай түргэн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд хамгийн ойр байгаа эрүүл мэндийн байгууллага болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн тасагт хандана.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
05 дүгээр сарын 13 өдрийн 688 Дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ГАДААДЫН ЖУУЛЧДЫГ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ВАКЦИНД ХАМРУУЛАХ, ТАНДАЛТ ХИЙХ ЗУРАГЛАЛ



ХИЛИЙН НЭВТРЭХ ЦЭГТ:




1. "Эрүүл мэндийн мэдүүлэг"
хуудас бөглөх




2. Термокамераар биеийн халуун
хэмжих



3. Эмнэлзүйн 3 шинж тэмдгийг
чагталсан, 38 хэмээс дээш
халуурсан бол **ТҮР** тусгаарлах



4. Өөрийн авчирсан антигенд
суурилсан түргэвчилсэн тестээр
шинжилгээ хийх, хариуг гаалийн
байцаагчид харуулах



5. Антигенд суурилсан
түргэвчилсэн тестээр **"ЭСРЭГ"**
гарвал хамгийн ойр Эрүүл
мэндийн байгууллагад хандах



АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН ҮЕД:

- ✓ Халуурах
- ✓ Ханиалгах
- ✓ Хоолой өвдөх,
- ✓ Хоолой сэрвэгэнэх
- ✓ Толгой өвдөх

- ✓ Хамар битүүрэх
- ✓ Нус гоожих
- ✓ Үнэрлэх, амтлах мэдрэхүй алдагдах
- ✓ Амьсгаадах

3 ба түүнээс дээш шинж тэмдэг илэрвэл



1. Аялал, жуулчлалын ажилтанд мэдэгдэх

2. Амны хаалт зүүх

✓ Бусдаас өөрийгөө тусгаарлах


✓ Өөрийн авчирсан антигенд

суурилсан түргэвчилсэн тестээр

шинжилгээ хийж, хариуг аялал

жуулчлалын компаний ажилтанд

мэдэгдэх




3. Антигенд суурилсан түргэвчилсэн тестээр
"ЭСРЭГ" гарвал бх-ПГУ шинжилгээнд:

- ОРОН НУТАГТ: хамгийн ойр Эрүүл мэндийн байгууллага
- НИЙСЛЭЛД: ХӨСҮТ, НЭМҮТ-д хандах

4. бх-ПГУ **"ЭСРЭГ"** гарвал:

- Ойрын хавьтлыг 5 хоног биеийн байдлаа ажиглах, амны хаалт зүүх, хүн хоорондын зай барихыг зөвлөх
- Батлагдсан тохиолдолд хавсралт 3-ын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх



Коронавируст халдвар (КОВИД-19)-
ын эсрэг вакцин **"ТӨЛБӨРГҮЙ"**
хамрагдана.

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЦЭГИЙН БАЙРШИЛ:



Байнгын
нэгж:

<https://moh.gov.mn/pr/147>



Түр цэг:

1. Улсын 2 дугаар төв эмнэлэг
2. Шангри-Ла худалдааны төв
3. Сүхбаатарын талбай



Явуулын
баг:

- 30-аас дээш бүрэлдэхүүнтэй багт очиж үйлчилнэ.
- Нийслэлд дүүргүүдийн ЭМТ-өөс баг ажиллана.



Цахим үйлчилгээний
нэгдсэн портал




Монгол, англи хэлээр авах боломжтой.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
05 дүгээр сарын 13 өдрийн 888 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН БАТЛАГДСАН ТОХИОЛДОЛД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗУРАГЛАЛ



5									
6									
7									
8									
9									
10									

Дараах шинж тэмдгийн аль нэг нэмж илэрвэл өрх, сум, тосгоны эмчид утсаар яаралтай мэдэгдэнэ. Үүнд:

- Өндөр халуурах /халуун бууруулах эм ууснаас хойш 2 цагийн дотор халуун буурахгүй байгаа/
- Амьсгал давчдах
- Бүтэн өгүүлбэрээр ярьж чадахгүй амьсгаадах
- Уруул, хэл, амны салст хөхрөх
- Ханиалгалт нэмэгдэх
- Цээжээр өвдөх
- Бөөлжих
- Суулгах
- Тууралт гарах
- Нүд үрэвсэх
- Булчингаар өвдөх

- Үе мөч өвдөх
- Хамраас цус гарах
- Татах
- Ухаан балартах

Хэрэв пульсоксиметр байгаа бол зааврын дагуу тайван үед хэрэглэж, 1 минут дахь зүрхний цохилтын тоо, SpO2 (сатураци) буюу захын цусны хүчилтөрөгчийн ханамжийг тодорхойлно. Үүнд:

- Зүрхний цохилтын тоо 1 минутад >100 байх
- SpO2 (сатураци) <94% байх.

Жич: Өвчтөнд амьсгал тоолох аргыг зааж өгсөн байх ба эсхүл эмнэлгийн мэргэжилтэн цахим үзлэг хийж, амьсгалын тоо, пульсоксиметрийн үзүүлэлтээр биеийн байдалд үнэлгээ өгнө.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
05 дүгээр сарын 18 өдрийн 1066 дугаар
тушаалын тавдугаар хавсралт

**ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ
УТАСНЫ ЖАГСААЛТ**

№	Аймаг, нийслэл	Утасны дугаар
1	Архангай	7033103
2	Баянхонгор	7044103
3	Баян-Өлгий	7042103
4	Булган	7034103
5	Говь-Алтай	7018103
6	Говьсүмбэр	7054103
7	Дархан-Уул	7037103
8	Дорнод	7052103
9	Дорноговь	7052103
10	Дундговь	7059103
11	Завхан	7046103
12	Орхон	7035103
13	Өвөрхангай	7032103
14	Өмнөговь	7053103
15	Сүхбаатар	7051103
16	Сэлэнгэ	7036103
17	Төв	7027103
18	Увс	7045103
19	Ховд	7043103
20	Хөвсгөл	7039103
21	Хэнтий	7056103
22	Улаанбаатар	103

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
05... дүгээр сарын 14 өдрийн АА дугаар
тушаалын зургаадугаар хавсралт

ГАДААДЫН ЖУУЛЧДАД ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗУРАГЛАЛ

